

Дарвийн бичээс

Ц. Баттулга*

Монгол Алтай судлалын хүрээлэнгээс хэрэгжүүлсэн “Монгол Алтайн археологийн дурсгалууд I” төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн нутаг дахь түүх археологийн дурсгалуудыг анх удаа харьцангуй бүрэн хэмжээгээр бүртгэн судалж тусгай бүтээл хэвлүүлсэн билээ.¹

Уг судалгааны ажлын үргэлжлэл болох “Монгол Алтайн археологийн дурсгалууд II” төсөл хэрэгжиж Ховд аймгийн нутаг дахь түүх археологийн дурсгалыг бүртгэн судалж байгаа болно. Энэ төслийн хүрээнд бид 2009 оны 8-р сард Ховд аймгийн Дарви сумын нутагт буй “Байшин үзүүрийн Жүргэрийн цагаан толгой” буюу түрэг судлаачдын дунд “Даривын эртний түрэг бичээс” хэмээн нэршсэн руни бичгийн дурсгалыг үзэж судалсан юм.

Алтайн нурууны салбар Ац богд, Бумбат богд уулын төгсгөл хэсэгт, Байшин үзүүрийн Жүргэрийн цагаан толгой хэмээх газар нэгэн зүйл бичээс буй хэмээсэн нутгийн олны аман мэдээг 1959 онд нэрт түүхч Х.Пэрлээ гуай тухайлан шалгаж руни бичиг болохыг нутласны хойно², 1968 онд Б.Ринчен профессор “Монгол нутаг дахь хадны бичээс гэрэлт хөшөөний зүйл” хэмээх бүтээлд³ гэрэл зургийг нь авч хэвлүүлсэнээр “Дарвийн эртний түрэг бичээс” шинжлэх ухааны эргэлтэд анх орсон байна.

* Монгол Улсын Их Сургууль, Гадаад Хэл Соёлын Сургууль

¹ Ц.Төрбат, Д.Баяр, Д.Цэвээндорж, Ц.Баттулга, Н.Баярхүү, Т.Идэрхангай, П.Х.Жискаар, Монгол Алтайн археологийн дурсгалууд –I, Баян-Өлгий аймаг, Улаанбаатар, 1999.

² М.Шинэхүү агсан эл бичээсийг уншиж тайлсан өгүүлэлдээ “Монгол Алтайн их нурууны нэгэн салбар болох “Шар булаг” хэмээх уулын өмнөд бэл этгээд “Байшин үзүүрийн Жүргэрийн цагаан толгой” гэдэг газар үл мэдэгдэх ямар нэгэн зураг бичээс байна гэсэн нутгийн хүмүүсийн аман яриаг эрдэмтэн Хөдөөгийн Пэрлээ гуай олж сонсоод, үзэж шинжихээр 1959 онд уг газар хүрэлцэн очиж эртний түрэг бичээс лавтай мөн болохыг таныгжээ” хэмээн тэмдэглэсэн байдаг. Харин Х.Пэрлээ гуайн бүтээл, тайлан тэргүүтэнд энэ талаар дурдсан, бичсэн нь үгүй. Хэдийгээр тийм боловч М.Шинэхүү гуай их эрдэмтэн, өтгөстэй хамт ажиллаж байсан, Х.Пэрлээ гуай ч руни бичгийн дурсгалын бүртгэл зэргийг хэвлүүлсэн зэргээс үзэхэд энэ мэдээнд эргэлзэх хэрэггүй, бат нуттай буй за. Үүнийг өгүүлэхийн учир, дээрх мэдээнд эргэлзэн тээнэгэлзэх судлаачид ч бий.

³ Rintchen, *Les dessins pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie* (Монгол нутаг дахь хадны бичээс гэрэлт хөшөөний зүйл), -Corpus Scriptorum Mongolorum, Institutum Linguae et Litterarum Academiae Scientiarum, Reipublicae Populi Mongolici, Tom. XVI, fasc. I, Улаанбаатар, 1968, 38-39 дүгээр тал.

Хожим 1969-1970 онуудад Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн “Хадны зураг, бичээс судлалын хэсэг” уг бичээсийг уншиж судлахаар зорьж очсон бөгөөд тэрхүү судалгааны ажлын үр дүнд уг бичээсийг түрэг судлаач М.Шинэхүү анх удаа уншиж тайлсан аж.⁴ Эл судалгаанаас хойш бичээсийг М.Шинэхүү абугайн галиг орчуулгаар танилцуулсаар иржээ.⁵

Оросын Шинжлэх Ухааны Академийн Хэлшинжлэлийн хүрээлэнгийн Түрэг судлалын салбарын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, нэрт эрдэмтэн, профессор И.В.Кормушин гуай 2004 оны 8-р сард эл бичээсийг Ховд Их сургууль, Тувагийн их сургуулийн хамтарсан хээрийн судалгааны ажлын хүрээнд үзэж судалсан байна. Тэрбээр 2005 онд “Тюркологический сборник” сэтгүүлд Дарвийн бичээсийг уншиж тайлсан судалгаагаа нийтлүүлэн⁶ улмаар 2006 онд Олон Улсын Монголч Эрдэмтдийн IX их хуралд илтгэл хэлэлцүүлж⁷, 2008 онд монгол хэлнээ орчуулж хэвлүүлсэн ажээ.⁸

Дарвийн бичээсийг судалсан хоёр эрдэмтний бичээсийн үсэг тэмдэгтийн хуулбар, сийрүүлгэ, уншлага өөр хоорондоо илэрхий зөрүүтэй. Үүнээс үүдээд түрэг судлаачдын дунд чухам хэний эх, хуулбар, уншлага судалгааг зөв гэж үзэх нь маргаантай асуудлын нэг байсан билээ. Тиймээс ч бидний “Дарвийн бичээсийг судлах” хээрийн шинжилгээний ажлын нэг гол зорилго нь бичээсийн эхийн үсэг тэмдэгтийг үнэн зөв сийрүүлэх байсан юм*. Өмнөх эрдэмтдийн эхийн хуулбар сийрүүлгэ, галиг, орчуулга зэргийг харьцуулан үзэхэд дөхөмтэйг бодож судалгааг тус тусад нь товч дурдахыг хичээлээ.

Төгсгөлд өөрсдийн судалгааг толилуулж байна. Бичээсийн эх, үсэг тэмдэгтийн хувьд ямар нэгэн маргаангүй бөгөөд харин уншиж тайлсан тухайд урьдчилсан судалгаа болно. Өөрөөр хэлбэл, Дарвийн бичээсийн эх буюу бичээсийн үсэг тэмдэгтийг түрэг судлаачдад үнэн зөвөөр хүргэх нь бидний энэ удаагийн зорилго юм.

⁴ М. Шинэхүү, *Даривын эртний түрэг бичээс*, Монголын эртний түүх-соёлын зарим асуудал, - *Studia Archaeologica, Instituti Historiae Academiae Scientiarum, Reipublicae Populi Mongolici*, Tom.V, fasc.3-13, Улаанбаатар, 1972, 135-147 дугаар тал.

⁵ Л.Болд, *Монгол нутаг дахь хадны бичээс*, Улаанбаатар, 1990, 28-29 дүгээр тал; Б.Батмөнх, Монгол Алтайн нурууны төв хэсгийн археологийн дурсгалууд, Улаанбаатар, 2008, 113-114 дүгээр тал.

⁶ И.В.Кормушин, *К прочтению надписи из местечка Шар-булаг в сомоне Дарв Ховдоского аймака* (Северо-Западная Монголия), - *Тюркологический сборник 2003-2004: Тюркские народы в древности и средневековье*, Москва, 2005, стр. 118-125.

⁷ И.В.Кормушин, *К дешифровке древней надписи из Дарв-сумона Ховдоского аймака МНР*, Улаанбаатар, 2006, Олон Улсын Монголч Эрдэмтдийн IX их хуралд хэлэлцүүлсэн илтгэл

⁸ И.В. Кормушин, *Монгол Улсын Ховд аймгийн Дарви сумын эртний бичээсийг тайлан уншсан тухай*, - Хэл зохиол судлал, Боть I (33), 1-20 дэвтэр, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэн (Linguistics and Literature, Institute of Language and Literature Mongolian Academy of Sciences), Улаанбаатар, 2008, 17-24 дүгээр тал.

*Бичээсийг гэрэл зураг, видео хальсанд буулгаж, хэв дардас авч баримтжуулсан болно.

М.Шинэхүү гуайн судалгаа⁹
Нэгдүгээр хадны бичээс:



Бичээсийн сийрүүлгэ:


ᠬᠤᠴᠢᠷᠪᠣᠮ
ᠠᠵᠢᠴᠢᠷᠠᠪᠢᠴᠢᠮ
(ᠬᠤᠴᠢᠷᠠᠪᠢᠴᠢᠮ)

Үсгийн галиг: J Ć U R B Q M
Үгийн галиг: AJ Ć UR ABĪQĪM

Төрөл зарим хэлтэй харьцуулбал:

Эртний түрэг: AJ Ć UR ABĪQĪM
Хасаг: AJ Ć UR ABAQĪM
Монгол бичиг: AJ Ć UR ABAQ-A MINU
Манж: MINI AJ Ć UR ABAQ-A
гэсэн ийм болой гэжээ.

Бичээс бүхүй 2-р хад:



Бичээсийн сийрүүлгэ:


ᠬᠤᠯᠤᠬᠤᠠᠲᠠᠶᠠᠪᠢᠲᠤ

Үсгийн галиг: K Ü L K T P A B I T,
Үгийн галиг: KÜLÜK ATA APA BIT

Төрөл зарим хэлтэй харьцуулбал:

Эртний түрэг: KÜLÜK ATA APA BIT
Хасаг: KÖLÖKTI ATA APA BITIMI
Монгол бичиг: NERETÜ EĀIGE EKE-YIN TÖRKÜTEN
Манж: GEBÜNGGE AMA EME-I (baningingge)
ÜYSÜNGGE гэсэн ийм болой гэжээ.

Бичээс бүхүй 3-р хад:



I бичээсийн сийрүүлгэ:

ᠠᠵᠢᠴᠢᠷᠠᠪᠢᠴᠢᠮ

Үсгийн галиг: J Ć UR B Q D M A,
Үгийн галиг: AJ Ć UR ABĪQ ADAMA

Төрөл зарим хэлтэй харьцуулбал:

Эртний түрэг: AJĆUR ABIQ ADAMA
Хасаг: AJĆUR ABAQ IN ADAMI
Монгол бичиг: AJĆUR ABAQ-A-YIN KÜMÜN
Манж: AJĆUR ABAQ-A-I NIYALMA
гэсэн ийм болой гэжээ.

⁹ М. Шинэхүү, *Даривын эртний түрэг бичээс*, Монголын эртний түүх-соёлын зарим асуудал, - Studia Archaeologica, Institutii Historiae Academiae Scientiarum, Reipublicae Populi Mongolici, Tom.V, fasc.3-13, Улаанбаатар, 1972, 135-147 дугаар тал.

3-р хадны II бичээсийн сийрүүлгэ:

ᠠᠪᠠᠰᠠᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠶᠢᠨ

Үсгийн галиг: I B A Š Q N Ć L M,

Үгийн галиг: IBAŠ AQ ANĆULAM

Төрөл зарим хэлтэй харьцуулбал:

Эртний түрэг: IBAŠ AQ ANĆULAM

Хасаг: IBAŠ AQ TIN ANAILAҮAN

Монгол бичиг: IBAŠ AQ-A-YIN AĆILAҮSAN

Манж: IBAŠ AQ-A-I XIYOŠÜLAXA

гэсэн ийм болой гэжээ.

3-р хадны III бичээсийн сийрүүлгэ:

ᠵᠢᠭᠢᠷᠮᠢᠪᠢᠨᠣᠨᠥᠯᠮᠻᠠᠨᠬᠠᠯᠢᠫᠢᠮᠠ

ᠠᠨᠣᠯᠢᠮᠻᠠᠨᠬᠠᠯᠢᠫᠢᠮᠠᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠶᠢᠨ

Үсгийн галиг: JGRMI BIN ON ÖLMKN KL

P ÖGÜ TOLҮ TOQIDI,

Үгийн галиг: JÄGIRMI ÄBIN ON ÖLMÄKÄN

KÄLIP ÖGÜ TOLAY TOQIDI

Төрөл зарим хэлтэй харьцуулбал:

Эртний түрэг: Jägirmi äbin on ölmäkän kälip ögü

tolay toqidi

Хасаг: Jirmä üjli on ölmäli kälip maqtaï toliq toqtadi

Монгол бичиг: Qorin kümün orun gertei, ügegüü

(ölberügsen) qoyusun arban kümün irejü
maytaju бүрин-е тоytaba (sayuba)

Манж: Orin niyalma oron boo bi, yüyüxe jûran

niyalma jifi maytaju yooni toytaxa

гэсэн ийм болой гэжээ.

М.Шинэхүү абугай эдгээр бичээсийн утгыг нэгтгэн орчин цагийн монгол хэлнээ утгачилан буулгасныг сийрүүлбэл “*Аячур Абак овогтон мань нэрт /алдарт/ эцэг эхий минь төрхтөн билээ. Аячур абак овгийн хүн Ибаиш Акын ачласан орон гэртэй 20 хүн үгээгай хоосон 10 хүн ирж, магтаж бүрнээ энд тогтов /суув/*” хэмээжээ.

И.В.Кормушин гуайн судалгаа¹⁰**Текст**

Восточная сторона: ᠵᠢᠭᠢᠷᠮᠢᠪᠢᠨᠣᠨᠥᠯᠮᠻᠠᠨᠬᠠᠯᠢᠫᠢᠮᠠ (1)

ᠠᠨᠣᠯᠢᠮᠻᠠᠨᠬᠠᠯᠢᠫᠢᠮᠠᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠶᠢᠨ (2)

Северная сторона: [ᠵᠢᠭᠢ]ᠠᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠶᠢᠨ (3)

Западная сторона: (4) Dᠯᠠᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠶᠢᠨ

Транслитерация

(1) *j čor bit'dim-ä

(2) j'g'irmi bin : on ölm'ä'n k'ä'p : ügü tol'Ү : toqidi

(3) jük'aj t'pa biti[d'im]

(4) *j čor bit'dim

Транскрипция

(1) aj čor bitidim-ä

(2) jägirmi bin on ölmäkin kängip ügü tol'Ү toqidi

(3) jükäj tapa biti[dim]

(4) aj čor bitidim

Перевод

(1) Ай-чор, я написал!

(2) Он наголову разбил двадцать тысяч, (из них) свыше десяти — насмерть.

¹⁰ И.В.Кормушин, *К прочтению надписи из местечка Шар-булаг в сумоне Дарв Ховдоского аймака* (Северо-Западная Монголия), - Тюркологический сборник 2003-2004: Тюркские народы в древности и средневековье, Москва, 2005, стр. 118-125; И.В.Кормушин, *К дешифровке древней надписи из Дарв-сумона Ховдского аймака МНР*, Улаанбаатар, 2006, Олон Улсын Монголч Эрдэмтдийн IX их хуралд хэлэлцүүлсэн илтгэл; И.В. Кормушин, *Монгол Улсын Ховд аймгийн Дарви сумын эртний бичээсийг тайлан уншсан тухай*, - Хэл зохиол судлал, Боть I (33), 1-20 дэвтэр, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэн (Linguistics and Literature, Institute of Language and Literature Mongolian Academy of Sciences), Улаанбаатар, 2008, 17-24 дүгээр тал.

(3) Для Юкея написал [я].

(4) Ай-чор, я написал.

Монгол хэлнээ орчуулсан нь:

(1) Ай-чор, би бичлээ!

(2) Тэр хорин мянган толгойг авч, (тэднээс) арав гаруйг нь үхүүлэв.

(3) Юке-д зориулан бичлээ [би].

(4) Ай-чор, би бичлээ.

Бидний судалгаа

Дарвийн бичээсийг М.Шинэхүү гуайн адил зүүн талаас нь дугаарласан болно.

Нэгдүгээр бичээс (Зүүн тал)

Эхийн сийрүүлгэ:

ᠡᠬᠢᠶᠡᠨᠰᠢᠢᠷᠦᠭᠦᠯᠭᠡᠢ.1

Dx:↓xH↖.2

Үсгийн галиг:

1. Y ě W R b t^dm

2. m [d]* t b R W ě Y

Үгийн галиг:

1. ay ěur bitidim

2. ay ěur biti[d]*im

Орчуулга:

1. Ай чур бичив би

2. Ай чур бичив би

* Нэгдүгээр мөрнөө энэхүү үсгийг нөхөж оруулжээ.

Харин хоёрдугаар мөрнөө уг үсгийг нөхөж оруулаасгүй байна.

Хоёрдугаар бичээс (Баруун тал)

Эхийн сийрүүлгэ:

ᠡᠬᠢᠶᠡᠨᠰᠢᠢᠷᠦᠭᠦᠯᠭᠡᠢ.1

ᠮᠤᠰᠢᠨᠡᠬᠦᠭᠦᠭᠡᠢᠭᠦᠢᠨᠭᠦᠢᠨᠠᠶᠢᠨᠠᠳᠢᠯᠤᠰᠤᠨᠲᠠᠯᠠᠰᠤᠨᠨᠢᠳᠦᠭᠦᠨᠲᠠᠯᠠᠰᠤᠨᠨᠢᠳᠦᠭᠦᠨᠲᠠᠯᠠᠰᠤᠨ.2

Үсгийн галиг

Y ě W R b i t* d m a .l

y g* m i b i n : o n ü l m k n k l p : ü g ü

T W L G : T W Q i D i .2

* Бичээсийг сийлэхдээ эдгээр үсгийг орхиж бичээд дараа нь дээр нь нөхөж оруулсан байна

Үгийн галиг:

ay ěur bitidimä .l

yägirmi bin on ülämkan kälip ügü toly toqidi .2

Утгачилсан орчуулга

Ай чур бичив би.1

Хорин мянга[аас] аравхан хэсэг нь ирж билигт тэмдэг тогтоолгов .2

Гуравдугаар бичээс (Хойд тал)

Эхийн сийрүүлгэ:

[ᠡᠬᠢᠶᠡᠨᠰᠢᠢᠷᠦᠭᠦᠯᠭᠡᠢ.1

Үсгийн галиг:

k ü k k T p a bit[dm]

Үгийн галиг:

kökkä tара biti[dim]

Орчуулга:

Хөхт хүслээ бичив би

Тэнгэрт хүсэл (зал- бирал)-аа бичив би

Бичээсийн утга агуулгыг харьцуулан тоймолбол:

М.Шинэхүү гуай: Аячур Абак овогтон мань нэрт /алдарт/ эцэг эхий минь төрхтөн билээ. Аячур абак овгийн хүн Ибаш Акын ачласан орон гэртэй 20 хүн үгээгүй хоосон 10 хүн ирж, магтаж бүрнээ энд тогтов /суув/.

И.В.Кормушин гуай: Ай-чор, би бичлээ!. Тэр хорин мянган толгойг авч, (тэднээс) арав гаруйг нь үхүүлэв. Юке-д зориулан бичлээ [би]. Ай-чор, би бичлээ.

Бид: Ай чур бичив би. Хорин мянга[аас] аравхан хэсэг нь ирж билигт тэмдэг тогтоолгов. Хөх тэнгэрт хүслээ бичив би.

Дээрх харьцуулалтаас үзэхэд бичээсийн уншлага судалгаа ямар их зөрүүтэй байгаа нь илт байна. Иймд түрэг судлаачид дахин нягтлах буй за.

НОМЗҮЙ

- Батмөнх Б, *Монгол Алтайн нурууны төв хэсгийн археологийн дурсгалууд I*, Баян-Өлгийаймаг, Улаанбаатар, 2008
- Болд Л, *Монгол нутаг дахь хадны бичээс*, Улаанбаатар, 1990
- Наделяев В.М, Насилов Д.М, Тенишев Э.Р, Щербак А.М, *Древнетюркский словарь*, Ленинград, 1969.
- Кормушин И.В, *К прочтению надписи из местечка Шар- булаг в сомоне Дарв Ховдоского аймака* (Северо-Западная Монголия), - Тюркологический сборник 2003-2004: Тюркские народы в древности и средневековье, Москва, 2005
- Кормушин И.В, *К дешифровке древней надписи из Дарв- сумона Ховдского аймака МНР*, Улаанбаатар, 2006, ОУМЭ-ийн IX их хуралд хэлэлцүүлсэн илтгэл, Кормушин И.В, *Монгол Улсын Ховд аймгийн Дарви сумын эртний бичээсийг тайлан унисан тухай*, - Хэл зохиол судлал, Боть I (33), 1-20 дэвтэр, Улаанбаатар, 2008
- Төрбат Ц, Баяр Д, Цэвээндорж Д, Баттулга Ц, Баярхүү Н, Идэрхангай Т, Жискара П.Х, Монгол Алтайн археологийн дурсгалууд –I, Баян-Өлгий аймаг, Улаанбаатар, 1999
- Шинэхүү М, *Даривын эртний түрэг бичээс*, Монголын эртний түүх-соёлын зарим асуудал, -Studia Archaeologica, Instituti Historiae Academiae Scientiarum, Reipublicae Populi Mongolici, Tom. V, fasc.3-13, Улаанбаатар, 1972
- Rintchen, *Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie* (Монгол нутаг дахь хадны бичээс гэрэлт хөшөөний зүйл), -Corpus Scriptorum Mongolorum, Instituti Linguae et Litterarum Academiae Scientiarum, Reipublicae Populi Mongolici, Tom. XVI, fasc. I, Улаанбаатар, 1968
- Sir Gerard Clauson, *An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish*, Oxford, 1972

ABSTRACT

This runic inscription is located at the place called Baishin Uzuuriin Jurgeriin Tsagaan Tolgoi, at the end of Ats Bogd and Bumbat Bogd, which can be found in the Altaic Mountain range near the Darvi soum of the Khovd province. The inscription was studied previously by M. Shinekhue and I.V. Kormushin.

Inscription One (Left side)

Original text:	Transliteration:	Transcription:	Translation:
ᠰᠢᠬᠡᠤᠬᠡᠭᠢᠳᠤ.1	1. Y č W R b t ^d m	1. ay čur bitidim	1. Written by Ay chur
ᠳᠠᠯᠠᠬᠠᠳᠤ.2	2. m [d] [*] t b R W č Y	2. ay čur biti[d] [*] im	2. Written by Ay chur

* *This letter was added in the first line. But this letter was not written in the second line.*



Inscription Two (Right side)

Original text:	ᠳᠠᠴᠢᠷᠪᠢᠳᠢᠮᠠ.1 ᠶᠭᠢᠷᠢᠮᠢᠨᠤᠯᠠᠮᠬᠠᠨᠬᠠᠯᠢᠯᠠᠭᠤᠲᠤᠯᠢᠶᠲᠣᠬᠢᠳᠢ.2
Transliteration:	Y č W R b i [*] d m a .1 y g [*] m i b i n : o n ü l m k n k l p : ü g ü T W L G : T W Q i D i .2 <i>*These words were left when it were carving in the inscription, but it was added later.</i>
Transcription:	ay čur bitidimä .1 yägirmi bin on ülämkän kälip ügü toľy toqıdĭ .2
Mongolian rendering:	Written by Ay chur.1 Ten out of twenty thousand came and erected this meaningful sign .2


Inscription Three (Back side)

Original text:	[ᠰᠢᠬᠡᠤᠬᠡᠭᠢᠳᠤ]ᠬᠢᠲᠤᠮᠠ.1
Transliteration:	k ö k k T p a bit[dm]
Transcription:	kökkä tapa biti[dim]
Translation:	I wrote my blessing to the Heaven.


Дарвийн бичээс



Нэгдүгээр бичээс



Хоёрдугаар бичээс



Гуравдугаар бичээс